

Феликс Николайвич Рянский*

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН БҮС НУТАГТ ОРОСЫН АЛС ДОРНОДЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Сүүлийн жилүүдэд Оросын Алс Дорнодын хөрш болох Япон, Бүгд Найрамдах Солонгос, ялангуяа Хятад Улс дэлхийн зах зээлийн харилцаанд нэлээд туршлага хуримтлуулаа, Эдгээр туршлагын гол нь;

1. Зах зээлийн эдийн засгийн замаар хөгжиж буй орнуудад Улсын эдийн засгийн эзлэх хувь, зонхилох үүрэг бага бөгөөд улс зөвхөн зохицуулалтын явцад л оролцох үүрэгтэй болов,

2, Үйлдвэр аж ахуйн газар ба Улсын эдийн засгийн үүрэг тус тусдаа саланги байх,

3, Эдийн засаг «хагас нээлттэй» буюу нээлттэй байх,

4. Үндэстний өвөрмөц, шилдэг сайн чанар-ажилсаг хөдөлмөрч, зохион байгуулалт, сахилга батыг эрхэмлэх, оюун санааны хувьд өөртөө итгэлтэй байх,

5, Мэдээллийн эх булгийг сайтар хэрэглэх, ашиглах,

6, Тусгай мэргэжил, техникийн боловсон хүчин бэлтгэх Харьцангуй өндөр системтэй болох гэх мэт,

Дээр дурьдсан улсууд, эхлээд тоталитаризм, милитаризм, хожим нь харилцан адилгүй хэмжээнд парламентарийн засаглалын хязгаарлагдмал, сохроор аялдан дагах дэглэмийг туулсан, буюу яг одоо туулж байна, Юуны өмнө, эдгээр улсын хямд ажиллах хүч, түүхий эд, ашигт малтмалын нөөц чухал ач холбогдолтой юм, Гэвч одоогоор Хятадаас бусад нь энэ давуу талаа нэгэнт алдаж, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн чанартай байгалийн баялаг улам бүр үнэтэй болсоор байна,

1991 оноос хуучин ЗХУ-ын эдийн засаг туршилт өөрчлөлтийн үе шатанд орж угийн байсан улс ардын аж ахуйн бүтэц туйлдаа хүртэл сүйрэн унав, Хэвшиж тогтсон эдийн засгийн нэр томъёогоор бол энэ үе нь «давагдашгүй эдийн засгийн үе» бөгөөд гадны нөлөөнд өртөж, бүтцийн ихээхэн өөрчлөлт гарсан үе юм, Социализмын үзэл санааны нөлөөнөөс болж, хөгжлийн урсгал явцын дунд эдийн засаг хөгжих нөхцөл төдий л бүрэлдээгүй, тухайн үеийн хүн амын дунд ардчилсан үзэл санааны хөрс суурь дутмаг зэргээс болж тус орон удаан хугацаагаар дэлхийн зах зээлээс саланги, уламжлалт зах зээлийн бүтэц дутагдалтай байсан билээ,

«Давтагдашгүй эдийн засгийн» нөхцөлд Улс эдийн засагт нөлөөлж буй онцгой нөлөөг эрж хайх, эдийн засгийг аль болох богино хугацаанд аяндаа хөгжих шилжилтийн үед оруулахаар чармайдаг. 1993 оны 12-р сард Оросын Холбооны Улсын Үндсэн хуулиар ерөнхийлөгчийн засаглалтай болсон

*Оросын ШУА-ийн Алс Дорнодын салбарын Бүс нутгийн асуудлын иж бүрэн задла шинжилгээний институтийн захирал, доктор, Профессор

юм, Түргэн хурдацтай өөрчлөлт, хуучин нийгмийн сүйрэл, үнэ Ханшны өсөлтийн нөхцөлд ерөнхийлөгчийн орон нутгийн өөрийгөө удирдах Удирдлага нь шилжилтийн үеийн бүс нутгийн хөгжлийн системд тогтвортой, баталгаажуулах үүрэг гүйцэтгэнэ,

Оросын Алс Дорнодын бүс нутаг (АДБН) бол Зүүн хойт Азийн зах зээлийн чухал, салшгүй бүрэлдэхүүн хэсэг, бүс нутгийн улс төрийн тогтвортой байдлын баталгаа юм, Энэ нутгийн байгалийн их нөөц баялаг, түүнийг нээж эзэмших нь ирээдүйд тус бүс нутгийг Зүүн Ази, Хойт Америк, Сибирь, Дундад Азийн олон газартай холбож, энд амьдарч буй 5 сая хүнийг мэргэжлийн хөдөлмөрт сургах, улмаар байгаль цаг Уурын хүнд хэцүү нөхцөлд аж төрөх нөхцөл бий болгоход чухал хүчин зүйл болох юм, Иймээс ч Оросын Алс Дорнодын бүс нутгийг Зүүн хойт Азийн бүс нутгийн нэгдмэл системд оруулах нь маш чухал юм, Үүний тулд, — «Олон улсын бүс нутгийн төлөвлөлт» бий болгох хэрэгтэй, Урт хугацааны урьдчилсан тооцоо, дунд хугацааны төлөвлөлт үүнд чиглүүлэгч үүрэгтэй, Үүний тул олон орны хамтарсан «Зүүн хойт Азийн хөгжлийн төв» байгуулах нь зайлшгүй болно, Хятадын Цицикар хотын Зүүн хойт Азийн бүс нутгийн асуудлыг судлах нь төв нь түр хугацаанд дээрх төвийн үүргийг гүйцэтгэж болох ба байнгын тогтвортой ажиллаж ажилтнуудтай байж, тэд нь Зүүн хойт Азийн олон орны эрдэмтэд, судлаачдыг нягт холбож өгөх юм, Орон бүрийн судлаачид өөрсдийн эрдэм шинжилгээний байгууллагад «төвийн» үүрэг гүйцэтгэж тус төв нь тус тусын эрдэм шинжилгээний байгууллагын салбар байж, ном хэвлэл хамтран бэлтгэх, харилцан дэмжиж, холбоо харилцаа тогтоох гэх мэт ажил хийж болох юм,

—«Мэдээллийн нэгдмэл систем бий болгох хэрэгтэй, Энэ нь баримт тоонд үндэслэсэн төлөвлөлт, удирдлага, технологийн баталгаа нийлүүлэх зэргийг хамарна, Их хэмжээний хөрөнгө оруулалтгүйгээр бүс нутгийн мэдээллийн сүлжээг бий болгох бололцоогүй бөгөөд тэгвэл ирэх зууны дунд үе хүртэл энэ ажил сунжирч болох юм, Хөрөнгө оруулалтыг төвлөрүүлсэн нөхцөлд энэ үйл явцыг хурдасгаж болох төдийгүй олон орны, хувь хүмүүсийн ч хөрөнгө мөнгийг татан оруулах хэрэгтэй, Үүний тул хөрөнгө оруулах таатай нөхцөл бий болгох, хөнгөлөлтийн систем байгуулах үндсэн дээр мэдээллийн байгууллагад хөрөнгө оруулах арга хэмжээ авч болно,

—Мэргэжилтэй, техникийн боловсон хүчинг бэлтгэх систем бий болгох нь чухал байна, Энэ нь бүс нутгийн хамтын хөгжлийн үндсэн арга хэмжээний нэг юм, Үүний тулд гадаадын хөрөнгө оруулалтын тусламжтайгаар (хувь хүний) Оросын АДБН-ийн дээд сургуулиудын сургалтын чанарыг дээшлүүлэх хэрэгтэй, Гадаадын профессоруудыг урьж ажиллуулах, гвьяслаг залуу багш нарыг өрнөдөд явуулж, мэргэжил дээшлүүлэх хэрэгтэй байна,

—«Аж үйлдвэрийг хөгжүүлэх төслийг» хэрэгжүүлэх хэрэгтэй, Оросын АДБН-т олон том төсөл хэрэгжүүлж болно, Эдгээр төслийг хэрэгжүүлэх нь олон нэгэн адил ашигтай,

Гэвч аль ч улс орон ийм төслийг дангаараа хэрэгжүүлж чадахгүй юм,

«Алс Дорнодын бүс нутгийг дамжин өнгөрөх тээврийн төсөл»-ийг хэрэгжүүлж болно, Төмөр зам, гүүр, олон улсын агаарын тээврийн дамжин өнгөрөх газар байгуулах, Амур мөрөн болон бусад гол мөрнөөр тээвэр хийх гэх мэт. Энэ төслийн зорилго нь олон төрлийн тээврийн хэрэгслийг ашиглан Оросын АДБН-ийг Хятад, хоёр Солонгос, Япон, Вьетнам, Монгол, Хойт Америктай холбож умартын «Сингапур» бий болгох явдал юм,

—«Оросын АДБН-ийн еврей (жүүд) үндэстэй өөртөө засах тойргоос Якут хүртэлх эх хуурай газрын эрчим хүчийг нээн ашиглах төсөл» гэж байж болно, Энд шаардагдах хөрөнгө оруулалтыг еврей үндэстний өөртөө засах тойргоос зохион байгуулж, мэргэжилтнийхээ хүчээр хэрэгжүүлж болно.

—«Амралт аялал жуулчлалын төсөл»-ийг Алс Дорнодын бүс нутгийн байгаль орчныг түшиглэн олон улсын жуулчлал, сувилалын газар байгуулах замаар хэрэгжүүлж болно, Үүний дотор АДБН-т олон улсын үндэстний цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил ч орно,

Хятад хэлнээс орчуулсан Л, БЭГЗЖАВ